

Монгол Улсын Их Хурлын Хууль
зүйн байнгын хорооны 2021 оны
06 дугаар тогтоолын хоёрдугаар
хавсралт

НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ

НЭГ. ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА:

1.1	Эцэг/эхийн нэр: Гансүх Ургийн овог: Боржигон Нэр: Буян Хүйс: Эм
1.2	Нэр дэвших тухай хүсэлт гаргаж буй албан тушаал Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүн
1.3	Иргэний харьяалал Тийм
1.4	Насны дээр хязгаар Үгүй
1.5	Улс төрийн болон намын удирдах албан тушаал Үгүй
1.6	Шүүгчийн албан тушаал Үгүй
1.7	Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Үгүй
1.8	Шүүхийн сахилгын хорооны гишүүн Үгүй
1.9	Шүүхийн захиргааны байгууллагын ажилтан Үгүй
1.10	Хуульч Тийм 2006-одоог хүртэл
1.11	Өмгөөлөгч Тийм 2010-одоог хүртэл
1.12	Прокурор Үгүй
1.13	Эрүүгийн хариуцлага Үгүй
1.14	Сахилгын шийтгэл Үгүй

ХОЁР. ХИЙХ АЖИЛ, НЭР ДЭВШСЭН ҮНДЭСЛЭЛЭЭ БИЧСЭН ТАЙЛБАР

2.1	
-----	--

Нэр дэвших болсон үндэслэл:

Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигч Г.Буян би хууль зүйн салбарт хуульч, өмгөөлөгчөөр ажилласан туршлага, мэргэжлийн ёс зүй, өмгөөллийн хуулийн этгээдийн үүсгэн байгуулагчийн хувиар эзэмшсэн удирдах, зохион байгуулах ур чадвартаа тулгуурлан, нийгмийн сайн сайхны төлөө шүүхийн ерөнхий зөвлөлийн үйл ажиллагаанд өөрийн хувь нэмрийг бодитойгоор оруулах зорилгоор нэр дэвшиж байна.

Өнөөдөр манай нийгэмд шүүх байгууллагын үйл ажиллагаа, шүүгчдийн хараат бус, ёс зүйн байдлын талаарх олон нийтийн итгэл хараахан хангалтгүй байгаа нь үнэн ч шүүхийн индекс өсөж байгаа нь тулгамдаж буй асуудлуудыг шат дараалалтайгаар шийдвэрлэж байгааг дурдах нь зүйтэй. Тухайлбал, Монгол улсын шүүхийн индекс 2021 онд 51.9 оноотой байсан бол 2023 онд 53.2 хувь болж өссөн байна. Хамгийн өндөр ахиц гарсан үзүүлэлт нь шүүгчийн ёс зүйн хариуцлага гэж үзсэн бол шүүхэд итгэх олон нийтийн итгэл 4.77 оноогоор буурсан байна.¹

Тиймээс Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвших болсон үндэслэлийг дараах хэрэгцээ шаардлагатай холбогдуулан гаргаж байна.

- Шүүхийн шинэчлэлийн хүрээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийн нэг болох шүүхийн бүтэц тогтолцоотой холбоотойгоор шүүхийн үйл ажиллагаа түргэн шуурхай байх, шүүхийн ачааллыг бууруулахын тулд шүүхийн үйл ажиллагааг цахим болгох, шүүхээс бусад байгууллагатай харилцахдаа цахимаар мэдээлэл авах боломжийг бий болгох болон төрийн байгууллагуудын чиг үүргийг харилцан уялдаа холбоотой зохион байгуулах шаардлагатай байна.
- Шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэлтэй байх, шүүхийн шийдвэр заавал биелэгддэг байхын тулд шүүгчийг мэргэших боломжоор хангах, шүүгчийн мэдлэг, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, шүүхийн ачааллыг бууруулах шаардлагатай.
- Олон нийт шударга ёсыг нэн түрүүнд шүүхээс эрэлхийлдэг. Авлигатай тэмцэх газраас “Төрийн байгууллагын шударга байдлын үнэлгээ”-г жил бүр гаргадаг хэдий ч шүүхийг үнэлсэн байдлын талаарх мэдээлэл олон нийтэд төдийлөн ил тод байхгүй байгаа нь шүүхэд итгэх иргэдийн итгэлийг бууруулах шалтгаан болж байна.

Иймд дээр дурдсан шалтгаан нөхцөл нь шүүхийн эрх хэмжээ, бие даасан байдал, шүүхийн нээлттэй, ил тод байдал, шүүхэд итгэх олон нийтийн итгэл, шүүхийн бүтэц, шүүгчийн ёс зүйн ба хариуцлагын асуудлыг шийдвэрлэх хэрэгцээ шаардлага байгаа гэдгийг харуулж байна.

¹ “Нээлттэй нийгэм форум” ТББ, “Оюуны-Инноваци ТББ”, “Монгол улс шүүхийн индекс 2023”, Улаанбаатар хот 2024 он, 72 дахь тал.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр томилогдвол дараах ажлыг санаачлан, шийдвэрлүүлэн ажиллана.

Шүүхийн тухай хуулийн 80, 82 дугаар зүйлд заасан Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүний бүрэн эрх, хүлээх үүргийг гүйцэтгэхийн зэрэгцээ уг хуульд заасан Шүүхийн ерөнхий зөвлөлийн чиг үүргийг хэрэгжүүлж ажиллана.

- **Шүүхийн бие даасан байдлыг хангах**

Шүүхийн бие даасан байдалд сөргөөр нөлөөлж болох аливаа хууль тогтоомжийн төсөлд хяналт тавьж, Үндсэн хуулийн зарчимд нийцүүлэх, тодорхой саналыг боловсруулж УИХ-д хүргүүлнэ. Түүнчлэн шүүхээс төрийн бусад байгууллагатай харилцахад тогтвортой, харилцан мэдээллийг шуурхай солилцох, ажил үүргийн чиг үүргийг тодорхой болгохтой холбоотой мэргэжлийн нэгдсэн сувгийг бий болгох асуудлыг санаачилж шийдвэрлүүлнэ. Шүүхийн бие даасан байдлын ач холбогдлыг олон нийтэд таниулж, шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэхээр ажиллана.

- **Шүүхийг хүний нөөцөөр хангах**

Шүүхийн үйл ажиллагааны чанар нь шүүхийн хүний нөөцийн чадвар болон хүрэлцээтэй байдлаас хамаардаг тул зөвхөн шүүгч төдийгүй, шүүхийн захиргааны ажилтнуудыг сонгон шалгаруулах, сургах тогтолцоог бүрдүүлэх нь ач холбогдолтой юм. Иймд шүүхийн захиргааны ажилтнуудыг сонгон шалгаруулах шалгуур үнэлгээг ил тод болгож, мэргэжлийн ур чадвараас гадна хувь хүний ёс зүй болон цаашид тогтвор суурьшилтай ажиллах эсэх талыг нь харгалзан шийдвэрлэх асуудал дээр анхаарч ажиллана.

Шүүгч болон захиргааны ажилтныг мэргэжлийн хувьд тасралтгүй хөгжих, ажиллах нөхцөлийг хангах тал дээр сургалт, солилцооны хөтөлбөрт хамруулах, цаашид шүүхэд тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлтэйгөөр дотоод, гадаадын их, дээд сургуулиудад богино хугацааны сургалтад хамруулах ажлыг зохион байгуулна.

Шүүхийн хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах зорилгоор хууль зүйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг их, дээд сургуулиудтай хамтран ажиллах ажлыг санаачлан хэрэгжүүлнэ. Хамтын ажиллагааны хүрээнд хууль зүйн сургуулийн оюутан, суралцагч нарт шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, шүүгчийн туслах, захиргааны ажилтны ажил үүргийг сурталчлан таниулна. Түүнчлэн, шүүхийн захиргааны ажилтны ажлын байранд тавигдах шаардлага хангасан төгсөгчдийн мэдээллийг их, дээд сургуулиас хүлээн авч хүний нөөцийн тогтвортой байдлыг хангуулна. Мөн ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшнийг тодорхойлох шалгуур үзүүлэлтэд үндэслэж албан тушаалын нэмэгдэл олгох, албан тушаалыг мэрт зарчмаар явах хөшүүрэг болгох журмыг тогтоож хэрэгжүүлнэ.

- **Шүүгчийн хараат бус байдлыг хангах, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах**

Шүүгчийн хараат бус байдлыг хангах, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах ажлын хүрээнд шүүгч өөрийн болон гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдлыг хамгаалуулах үүднээс аливаа дарамт, нөлөөлөлтэй холбоотой мэдээллийг өгөх, хамгаалуулах арга хэмжээг түргэн шуурхай авах цогц системийг хөгжүүлэх ажлыг санаачилж, ажил хэрэг болгоно.

Шүүгчийн хараат бус байдалд нөлөөлсөн хэргийн талаарх шийдвэр, баримтуудыг тогтмол танилцуулж, шүүгчдээс хараат бус байдалд нөлөөлж болзошгүй нөхцөл, байдлын талаарх судалгаа, мэдээллийг сар бүр нийтэлж, олон нийтэд хүргэх замаар шүүгчийн хараат бус байдлыг хангаж ажиллана.

МУ-ын шүүхийн тухай хуульд заасны дагуу нийт шүүгчдийн чуулганаар баталсан “Хэрэг, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах, хэрэг маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нийтлэг журам”-аар зохицуулагдаагүй нөхцөл байдал үүсэж байгаа нь шүүхийн ачааллыг нэмэгдүүлж байна. Иймд хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох журмыг хэрэгжүүлэхдээ шүүгчийн ачааллыг тэнцвэржүүлэх, хэрэг, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах, хэрэг маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг томилох программ хангамжийн ажиллагаа болон аюулгүй байдлыг хангаж, иргэдэд нээлттэй, ил тод байлгах зорилгоор хиймэл оюун ухааны тусламжтайгаар боловсронгуй болгох ажлыг санаачлан ажиллана.

- **Шүүхийн санхүү, эдийн засгийн баталгааг хангах**

Шүүхийн төсвийн бие даасан байдлыг хангаж, гүйцэтгэх эрх мэдлээс хараат бус байлгах зорилгоор хууль эрх зүйн орчныг сайжруулах асуудлыг шүүхийн ерөнхий зөвлөлийн хурлаар шийдвэрлүүлнэ. Шүүхийн мэдээллийн технологи, шүүгч болон захиргааны ажилтан нар хэвийн ажиллах нөхцөлийг хангах шаардлагын хүрээнд урт хугацааны тогтвортой төсөв батлуулахтай холбоотой асуудлыг судалж, дүгнэлт гаргана. Баталсан төсвийг үр ашигтай зарцуулах зорилгоор шүүхүүдийн төсвийг хэрэгцээнд нь нийцүүлэн хуваарилж, түүнд тавих хяналтын тогтолцоог бий болгож, төсвийн зарцуулалтын ил тод байдлыг бий болгоно.

- **Мэдээллийн ил тод байдлыг хангах**

Шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг бэхжүүлэх хамгийн чухал хэрэгсэл бол үнэн зөв мэдээллээр шуурхай хангах асуудал юм. Иймд, шүүхээс гарсан судалгаа, дүн шинжилгээ болон шүүхийн үйл ажиллагааны үр дүнд, шүүхийн шийдвэр, түүний биелэлтийн талаар тогтмол, олон нийтэд нээлттэй хэлбэрээр мэдээлэх боломжийг бий болгоно. Түүнчлэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр

	шүүхийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг олон нийтэд мэдээлэхдээ холбогдох эх сурвалжид үндэслэсэн байх шаардлагыг бий болгох, хууль эрх зүйн мэргэшсэн сэтгүүлчээр мэдээллийг тогтмол таниулах ажиллагааг бий болгоно. Дээр дурдсанаас гадна Монгол улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого болон шүүхийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх, холбогдох эрх зүйн актыг боловсронгуй болгох, хэрэгжүүлэхэд хуулиар хүлээсэн үүргийн дагуу оролцож, хуульд нийцсэн саналыг дэвшүүлж байх болно.
--	---

ГУРАВ. МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАНИЛЦУУЛГА

Д/д	Шалгуур үзүүлэлт
3.1	Боловсрол 2013-2017 онд БНСУ-ын Күүкмин их сургуулийн Төгсөлтийн дараах сургуулийн хууль зүйн ухааны докторын хөтөлбөрт суралцаж кредит дүүргэсэн гэрчилгээ авсан. 2004-2006 онд Цагдаагийн академид суралцаж, хууль зүйн магистрын зэрэг хамгаалсан. 1998-2002 онд Чингис хааны нэрэмжит Их Засаг их сургуулийг “эрх зүйч” мэргэжлээр суралцаж төгссөн.
3.2	Эрх зүйч мэргэжлээр ажилласан байдал 1. 2013 оны 8 сараас одоог хүртэл Өмгөөллийн “Эл Би Паарнаас” ХХК-д тасралтгүй 12 жил ажиллаж байна. 2013-2023 он хүртэл гүйцэтгэх захирал албан тушаалд 9 жил ажилласан. Тухайн албан тушаалд ажиллахдаа компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, үйлчлүүлэгчтэй харилцах, үйлчлүүлэгчид хууль зүйн зөвлөгөө өгөх, шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үйлчлүүлэгчийн өмгөөлөгчөөр оролцож ажилласан. 2023-одоог хүртэл партнер өмгөөлөгч албан тушаалд 2 жил ажиллаж байгаа бөгөөд эрүү, иргэн, захиргааны хэрэгт өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх, компанийг удирдахад гүйцэтгэх захиралд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Удирдах албан тушаалтан: С.Нансалмаа Хамт ажиллаж байгаа хүн 1: Г.Зина, Өмгөөллийн “Эл Би Партнерс” ХХК-ийн хуулийн зөвлөх Хамт ажиллаж байгаа хүн 2: Б.Гэрэлтуяа, Өмгөөллийн “Эл Би Партнерс” ХХК-ийн өмгөөлөгчийн туслах Хамт ажиллаж байгаа хүн 3: Д.Туяа, Өмгөөллийн “Эл Би Партнерс” ХХК-ийн хуулийн зөвлөх Хамт ажиллаж байгаа хүн 4: Ж.Төрмөнх, Өмгөөллийн “Эл Би Партнерс” ХХК-ийн хуульч, өмгөөлөгч Хамт ажиллаж байгаа хүн 5: Лим Тэ Сү, Өмгөөллийн “Эл Би Партнерс” ХХК-ийн партнер өмгөөлөгч 2. 2022-2025 он хүртэл Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр 3 жил ажилласан. Тус албан тушаалд ажиллахдаа Монгол улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 20.1-д заасан ТУЗ-ийн бүрэн эрхийн хүрээн дэх эрх, үүргийг хэрэгжүүлэн ажилласан. Тухайлбал, Хөгжлийн банкны тухайн жилийн бизнес төлөвлөгөөг батлах, үйл

	ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийг батлах ажлыг гүйцэтгэж ажилласан. Удирдах албан тушаалтан: Б.Анар, Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Хамт ажиллаж байгаа хүн 1: Б.Анар, Хөгжлийн банкны ТУЗ-ийн дарга Хамт ажиллаж байгаа хүн 2: Б.Энхтуяа, Хөгжлийн банкны ТУЗ-ийн хараат бус гишүүн Хамт ажиллаж байгаа хүн 3: Б.Чойжил, Хөгжлийн банкны ТУЗ-ийн ердийн гишүүн Хамт ажиллаж байгаа хүн 4: Ц.Чандмань, Хөгжлийн банкны ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитын газрын захирал Хамт ажиллаж байгаа хүн 5: П.Нэргүй, Хөгжлийн банкны ТУЗ-ийн нарийн бичгийн дарга 3. 2010-2013 он хүртэл “Хан Маум” ХХК-ийн өмгөөлөгч албан тушаалд 3 жил 6 сар ажилласан. Тус албан тушаалд ажиллахдаа Монгол болон БНСУ-ын үйлчлүүлэгчдийг хариуцан, тэдний шүүхийн маргаанд өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх, хууль зүйн зөвлөгөө өгөх, компани байгуулах, хөрөнгө оруулалт зэрэг чиглэлээр хууль зүйн мэргэжлийн туслалцааг үзүүлж байсан. Удирдах албан тушаалтан: Ч.Дариймаа Хамт ажиллаж байсан хүн 1: О.Бат-Эрдэнэ, Хамт ажиллаж байсан хүн 2: С.Эрдэнэчимэг, Хамт ажиллаж байсан хүн 3: Ч.Дариймаа, Хамт ажиллаж байсан хүн 4: О.Нанжид Хамт ажиллаж байсан хүн 5: С.Туяацэцэг 4. 2006-2007 он хүртэл Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Хан-Уул дүүргийн 137 дугаар тойрогт шийдвэр гүйцэтгэгч албан тушаалд 6 сар ажилласан. Тус албан тушаалд ажиллахдаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 44, 77, 271.1 дэх заалтуудад заасан үйл ажиллагааг гүйцэтгэж ирсэн. Тодруулбал, төлбөр төлөгчийн хөрөнгөөс суутгал хийх, төлбөр төлөгчийн үйл ажиллагаанд холбогдох санхүүгийн болон бусад баримт бичигт үзлэг хийх зэрэг багтана. Удирдах албан тушаалтан: Б.Түвшинтөгс Хамт ажиллаж байсан хүн 1: Д.Анхтуяа Хамт ажиллаж байсан хүн 2: Д.Жаргалсайхан Хамт ажиллаж байсан хүн 3: О.Баяржаргал Хамт ажиллаж байсан хүн 4: Б.Өлзийсайхан Хамт ажиллаж байсан хүн 5: Б.Батболд 5. 2005-2006 он хүртэл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын Боловсон хүчин, сургалтын хэлтэст хэрэг хөтлөгч албан тушаалд 1 жил 1 сар ажилласан. Тус албан тушаалд ажиллахдаа ажилд шинээр томилох, чөлөөлөх тушаалын төсөл боловсруулах, хүний нөөцийн бодлогын ажлыг хэрэгжүүлж ажилласан. Удирдах албан тушаалтан: Б.Нандинболор
--	---

	Хамт ажиллаж байсан хүн 1: Р.Оюун Хамт ажиллаж байсан хүн 2: А.Намсаманд, Хамт ажиллаж байсан хүн 3: Э.Наранхүү Хамт ажиллаж байсан хүн 4: Б.Тамир Хамт ажиллаж байсан хүн 5: Н.Мөнхжаргал
3.3	Эрх зүйчээс бусад мэргэжлээр эрхэлсэн ажил Үгүй
3.4	Хууль зүйн өндөр мэргэшил 1. Үйл ажиллагааны нэр: Шүүхэд хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөх, өмгөөлөгчөөр оролцох Эрхэлсэн газар: Монгол улс, Улаанбаатар хот Хугацаа: 2024-одоог хүртэл Гол агуулга: Шүүхийн шийдвэр заавал биелэгдэх зарчмыг хангах ажилд хувь нэмрээ оруулан Гадаад улсын шүүх, арбитрын шийдвэрийг Монгол улсад гүйцэтгэх, Монгол улсын шүүх болон арбитрын шийдвэрийг гадаад улсад биелүүлэх ажиллагаанд өмгөөлөгчийн хувиар оролцож байна. Тухайлбал, гадаад улсад амьдарч буй монгол иргэд, эсхүл Монгол улсад оршин суугаа гадаад улсын иргэдийн хувьд хууль зүйн туслалцаа авах нөхцөл нь өөрийн байнга оршин суудаггүй улсад хууль, эрх зүйн ажиллагаа явуулна гэдэг талаасаа ихээхэн хүндрэлтэй байдаг. Иймд энэ төрлийн асуудалд миний бие нь хоёр улсын хоорондын эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ болон холбогдох олон улсын гэрээ, конвенцийн хүрээнд хууль зүйн мэргэжлийн туслалцааг үзүүлж байна. Жишээлбэл, БНХАУ-ын иргэнд холбогдох дундын эд хөрөнгөтэй холбоотой хэрэгт нэхэмжлэгч Монгол улсын иргэнд хууль зүйн мэргэжлийн үйлчилгээ үзүүлсэн бөгөөд ингэхдээ БНМАУ, БНХАУ-ын хооронд иргэний болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ болон Улсын дээд шүүхийн тогтоолын дагуу нэхэмжлэлийг гардуулах ажиллагааг хоёр улсын дээд шүүхээр дамжуулан хийлгүүлсэн. Үр дүн, түүний жишээ: Ингэснээр хариуцагчийн хаяг тодорхойгүй байдлаас болж зөрчигдсөн эрхээ сэргээлгэж чадахгүй байдалд орсон нэхэмжлэгчийн эрхийг хамгаалах ажил амжилттай явагдсан. Нотлох баримт: Эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээгээр БНХАУ-ын ардын шүүхэд “хариуцагчид нэхэмжлэлийг гардуулах” ажлыг даалгасан шүүгчийн захирамжийн хуулбар болон өмгөөлөгчөөр оролцуулах хүсэлтийн хуулбарыг хавсаргав. Үйл ажиллагааг удирдсан албан тушаалтан: Г.Буян Хамтран ажиллаж байгаа хүн 1: С.Нансалмаа Хамтран ажиллаж байгаа хүн 2: Бао Лили (Bao Lili) Удирдлагад ажиллаж байгаа хүн 3: Г.Оюунчимэг 2. Үйл ажиллагааны нэр: БНСУ-тай холбоотой ажил Эрхэлсэн газар: БНСУ Хугацаа: 2016-одоог хүртэл Гол агуулга: БНСУ-д ажиллаж, амьдарч буй Монгол иргэдэд хууль зүйн туслалцааг илүү ойроос хүргэхийн тулд өөрийн үүсгэн байгуулсан өмгөөллийн хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрыг БНСУ-д үүсгэн байгуулсан. Мөн 2016 оноос хойш одоог хүртэл БНСУ-аас МУ-д суугаа

элчин сайдын яамны эрүүгийн хэрэг хариуцсан консулын гэрээт өмгөөлөгчөөр ажиллаж байна. Түүнчлэн, БНСУ-ын шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэгч Монгол улсын иргэний хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахаар Монгол улсын Иргэний хуулийн өв залгамжлалтай холбогдох заалтыг хэрэглэх саналыг БНСУ-ын өмгөөлөгчөөр дамжуулан гаргаж, тухайн шүүхийн шийдвэрийн үндэслэл болгуулсан. Мөн, Монгол улсын иргэний эрх ашгийг төлөөлж гэрлэлт цуцлуулах болон сэтгэл санааны хохирлыг нэхэмжлэхтэй холбоотой хэрэгт Монгол улс дахь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах ажлыг хийж гүйцэтгэсэн.

Үр дүн, түүний жишээ: Монгол улс болон БНСУ-ын хууль, эрх зүйн хамтын ажиллагаа, харилцан туслалцааны асуудалд хувь нэмрээ оруулсан. Гадаадад байгаа Монголчуудад хууль зүйн үйлчилгээг саадгүй авах боломжийг олгосон.

Нотлох баримт: Төлөөлөгчийн газрын гэрчилгээний хуулбар (орчуулгын хамт), БНСУ-аас МУ-д суугаа элчин сайдын яамтай байгуулсан гэрээний хуулбар, БНСУ-аас МУ-д суугаа элчин сайдын яамны тодорхойлолт (орчуулгын хамт), Дэжон хотын Чонан орон нутгийн шүүхийн шийдвэрийн хуулбар (орчуулгын хамт), Дэжон гэр бүлийн шүүхийн Чонан орон нутгийн шүүхийн шийдвэрийн хуулбар (орчуулгын хамт)-ыг хавсаргав.

Үйл ажиллагааг удирдсан албан тушаалтан: Г.Буян

Хамтран ажиллаж байгаа хүн 1: И Ү Сон

Хамтран ажиллаж байгаа хүн 2: Лим Тэг Сог

Удирдлагад ажиллаж байгаа хүн 3: Н.Золзаяа

3. **Үйл ажиллагааны нэр:** Докторын судалгааны ажил

Эрхэлсэн газар: БНСУ, Сөүл хот

Хугацаа: 2013-одоог хүртэл

Гол агуулга: БНСУ-ын Күүкмин их сургуулийн Төгсөлтийн дараах сургуулийн хууль зүйн ухааны докторын сургалтын хөтөлбөрт хамрагдаж кредит дүүргэсэн гэрчилгээг авсан бөгөөд “Захиргааны хэргийн шүүхэд гаргах нэхэмжлэлийн шаардлагын төрлийг харьцуулсан судалгаа (Монгол улсын жишээг БНСУ-тай харьцуулсан судалгаа)” сэдвээр докторын судалгааны ажлаа бичиж байна.

Үр дүн, түүний жишээ: Тус судалгааны ажлын хүрээнд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.3.3 дахь заалтын талаар нарийвчлан судалсан бөгөөд үүнийгээ “Нээлттэй нийгэм форум” ТББ-с эрхлэн гаргадаг “Шүүхийн шийдвэрийн судалгаа” цуврал 6-д нийтлүүлсэн.

Нотлох баримт: Кредит дүүргэсэн гэрчилгээ, дүнгийн тодорхойлолтын хуулбар (орчуулгын хамт) болон дипломын ажил хийж байгаа болохыг нотлох баримтыг хавсаргав.

Үйл ажиллагааг удирдсан албан тушаалтан: Г.Буян

Хамтран ажилласан хүн 1: Ким Мин Соб

Хамтран ажилласан хүн 2: С.Нансалмаа

Хамтран ажилласан хүн 3: Лим Тэ Сү

4. **Үйл ажиллагааны нэр:** Хуулийн төсөлд санал оруулах

Эрхэлсэн газар: Монгол улс, Улаанбаатар хот

Хугацаа: 2022-одоог хүртэл

Гол агуулга: Хууль тогтоомжийн тодорхой байдал, судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх байдал зэрэг зарчмын хэрэгжилтэд хуульч хүний хувьд хувь нэмрээ оруулахын тулд “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль”-ийн төсөл зэрэгт саналаа өгч оролцсон. Тодруулбал, “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд “шүүхийн шийдвэрт түүнийг биелүүлэх хугацааг тусгаж, тус хугацаанд биелүүлээгүй тохиолдолд хүү тооцох” талаар тусгах тухай саналыг Хууль зүйн яаманд хүргүүлсэн. “Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль”-ийн төсөлд гэр бүлийн нөхцөл байдлын шинжээч, хариуцагчийн эзгүйд гэрлэлт цуцлах асуудал зэргийг илүү боловсронгуй болгох саналаа хүргүүлсэн. Түүнчлэн, тус хууль батлагдсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбогдуулан “Гэр бүлийн тухай хууль”-д “хүүхдийн тэтгэмжийг тогтоохдоо шүүхийн шийдвэр гарсан өдрөөс бус хүүхэд төрснөөс эхэлж тогтоолгох” асуудалтай холбоотой тодорхой саналыг дэвшүүлэн хүргүүлсэн. Эдгээр хуулийн төсөлд санал өгөхдөө БНСУ болон БНХАУ-ын холбогдох хууль тогтоомж болон шүүхийн шүүхийн шийдвэрт үндэслэн гаргасан болно. “Өмгөөллийн тухай хууль”-ийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалтын хэрэгжилтийг хангахад туслалцаа үзүүлэх хүсэлтийг Монголын Хуульчдын холбоонд гаргасан.

Үр дүн, түүний жишээ: “Өмгөөллийн тухай хууль”-ийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалтын талаар төрийн болон төрийн бус байгууллагуудад ойлголт өгөхөд хувь нэмрээ оруулсан. “Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль”-ийн төсөлд өгсөн саналыг ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтэсээс хянаж байна.

Нотлох баримт: “Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль”-ийн төсөлд өгсөн саналын хуулбарыг хавсаргав.

Үйл ажиллагааг удирдсан албан тушаалтан: Лим Тэ Сү

Хамтран ажиллаж байсан хүн 1: Ван Юүлин (Wang Yulin)

Хамтран ажиллаж байсан хүн 2: Б.Гэрэлтуяа

Хамтран ажиллаж байсан хүн 3: Н.Золзаяа

5. **Үйл ажиллагааны нэр:** Хөгжлийн банкны ТУЗ-ийн гишүүн

Эрхэлсэн газар: Монгол улс, Улаанбаатар хот

Хугацаа: 2022-2025 он

Гол агуулга: Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны даргаар ажилласан. Тус хугацаанд Монгол улсын Хөгжлийн банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд санал оруулах, Азийн хөгжлийн банкны 56 дахь чуулга уулзалтад оролцох, банкны чанаргүй активыг эргэн төлүүлэх ажлыг шийдвэрлэх зэрэг ажилд хувь нэмрээ оруулан ажилласан.

Үр дүн, түүний жишээ: Хөгжлийн банкны зээлийн эргэн төлөлтөөс бүрдүүлсэн эх үүсвэрээр 500 сая ам.доллар болон 30 тэрбум иенийн үнийн дүн бүхий бондын өрийг амжилттай төлж барагдуулахад хувь нэмэр оруулсан.

Нотлох баримт: ТУЗ-ийн гишүүнээр томилогдсон, чөлөөлөгдсөн тушаалын хуулбар болон авсан шагналын зургийг хавсаргав.

Үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр: Б.Анар

Хамтран ажиллаж байсан хүн 1: Б.Энхтуяа
Хамтран ажиллаж байсан хүн 2: Б.Чойжил
Хамтран ажиллаж байсан хүн 3: П.Нэргүй

6. **Үйл ажиллагааны нэр:** Судалгааны ажил
Эрхэлсэн газар: Монгол улс, Улаанбаатар хот
Хугацаа: 2022 он
Гол агуулга: “Дуусгавар болсон актад холбогдуулан нэхэмжлэл гаргах эрх (Харьцуулсан эрх зүйн судалгаа)” сэдвийн хүрээнд судалгаа хийсэн.
Үр дүн, түүний жишээ: “Нээлттэй нийгэм форум” ТББ-ын санаачилгаар улирал болгон хэвлэн гаргадаг “Шүүхийн шийдвэрийн судалгаа” цувралын 6 дахь дугаарт нийтлэгдсэн.
Нотлох баримт: “Шүүхийн шийдвэрийн судалгаа” цуврал 6 номыг хавсаргав. Үүний 9-34 дэх талд тусгагдсан болно.

Үйл ажиллагааг удирдсан албан тушаалтан: Д.Эрдэнэчимэг

Хамтран ажилласан хүн 1: С.Нансалмаа
Хамтран ажилласан хүн 2: Д.Отгоннасан
Хамтран ажилласан хүн 3: Юүн Чан Ин

7. **Үйл ажиллагааны нэр:** Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн хэрэгжилттэй холбоотой хөндлөнгийн хяналт, шинжилгээ, үнэлгээ, зөвлөх үйлчилгээ
Эрхэлсэн газар: Монгол улс, Улаанбаатар хот
Хугацаа: 2022 он
Гол агуулга: 1999 оны Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн хэрэгжилттэй холбоотой хөндлөнгийн хяналт, шинжилгээ, үнэлгээ, зөвлөх үйлчилгээг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газарт үзүүлсэн. Ингэхдээ “Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо” ТББ-тай хамтарсан бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг Монгол улсын баруун 5 аймгийн хүрээнд судлаж, холбогдох зөвлөмжийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газарт хүргүүлсэн.
Үр дүн, түүний жишээ: Баруун 5 аймагт хуулийн дээрх заалт хэрхэн хэрэгжиж байгаа, хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг хэрхэн дэмжиж байгаа зэргийг тандан судалснаар хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд дэмжлэг болсон.
Нотлох баримт: Үнэлгээний тайлангийн нэгдүгээр бүлгийн хуулбар болон түншлэлийн гэрээний хуулбарыг хавсаргав.

Үйл ажиллагааг удирдсан албан тушаалтан: “Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо” ТББ, тэргүүн Л.Энхбаяр

Хамтран ажиллаж байсан хүн 1: С.Нансалмаа
Хамтран ажиллаж байсан хүн 2: Д.Мягмарсүрэн
Хамтран ажиллаж байсан хүн 3: Э.Төгөлдөр

8. **Үйл ажиллагааны нэр:** Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ хийх ажил
Эрхэлсэн газар: Монгол улс, Улаанбаатар хот
Хугацаа: 2021-2022 он

Гол агуулга: “Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль”-ийн төслийн үр нөлөөний үнэлгээг “Хууль тогтоомжийн тухай хууль”-д заасны дагуу зорилгод хүрэх байдал, ойлгомжтой байдал, харилцан уялдаа гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийж гүйцэтгэн, холбогдох зөвлөмжийг өгсөн.

Үр дүн, түүний жишээ: Тус ажлын үр дүнд хуулийн төслийг хэрэгжүүлэхэд нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчин, төрийн байгууллага болон иргэдэд үзүүлэх үр дагаврыг урьдчилан тодорхойлох, тооцоолох боломж бүрдсэн.

Нотлох баримт: Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний хуулбарыг хавсаргав.

Үйл ажиллагааг удирдсан албан тушаалтан: Г.Зина

Хамтран ажиллаж байсан хүн 1: Г.Ганхуяг

Хамтран ажиллаж байсан хүн 2: Д.Отгоннасан

Хамтран ажиллаж байсан хүн 3: С.Нансалмаа

9. **Үйл ажиллагааны нэр:** Хууль зүйн чиглэлээр багшлах

Эрхэлсэн газар: Монгол улс, Улаанбаатар хот

Хугацаа: 2021 оны 1 дүгээр улирал

Гол агуулга: БНСУ-ын Күүкмин их сургуульд захиргааны эрх зүйн чиглэлээр дипломын ажил бичиж байгаа докторантын хувьд Монгол улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийн Солонгосын эрх зүйн боловсролын төвийн 2 дугаар курсын оюутнуудад “БНСУ-ын Захиргааны эрх зүй” хичээлийг заасан. Солонгосын эрх зүйн боловсролын төв нь БНСУ-ын Күүкмин их сургууль болон МУИС-ийн Хууль зүйн сургууль хоорондын хамтын ажиллагааны гэрээний дагуу 2011 оны 10 сард үүсгэн байгуулагдсан бөгөөд эрх зүйн ангийн оюутнуудад үндсэн хичээлээсээ гадна солонгос хэл болон солонгосын эрх зүйг давхар сурах боломжийг олгодог төв юм.

Үр дүн, түүний жишээ: Солонгосын эрх зүйгээр мэргэшиж буй оюутнуудад солонгосын эрх зүйн суурь болон гүнзгийрүүлсэн сургалт явуулж Монгол улсад Солонгосын эрх зүйгээр мэргэшсэн боловсон хүчин бэлтгэх ажилд хувь нэмэр оруулсан. Үүнтэй холбоотойгоор оюутан сурагчдад мэдлэг, ур чадвар, зөв хандлага олгоход үнэтэй хувь нэмэр оруулсан гэж БНСУ-ын Күүкмин их сургуулиас талархлын цом өгсөн.

Нотлох баримт: Багшилсан нь үнэн тодорхойлолт (орчуулгын хамт) болон талархлын цомын зургийг хавсаргав.

Үйл ажиллагааг удирдсан албан тушаалтан: Ким Дун Хүн

Хамтран ажилласан хүн 1: А.Дэжидмаа

Хамтран ажилласан хүн 2: Ким Дун Хүн

Хамтран ажилласан хүн 3: Д.Мягмарсүрэн

10. **Үйл ажиллагааны нэр:** Шүүхэд хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөх, өмгөөлөгчөөр оролцох

Эрхэлсэн газар: Монгол улс, Улаанбаатар хот

Хугацаа: 2019-2020 он

Гол агуулга: Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10 дахь заалтын дагуу байгалийн нөөц

	баялгийг эрэх, хайх, ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч нэг бүр нь “байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай данс”-нд хуульд заасан хэмжээний мөнгөн хөрөнгийг төвлөрүүлэх үүрэгтэй боловч тус заалтын бодит хэрэгжилт тодорхойгүй, ил тод бус байсан тул энэ талаарх мэдээллийг иргэдэд нээлттэй мэдээллийн шаардлага хангасан форматаар өөрийн цахим хуудсанд мэдээллэж байхыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамд даалгах нэхэмжлэл бүхий захиргааны хэрэгт нийтийн эрх ашгийг төлөөлөн нэхэмжлэгчийн өмгөөлөгчөөр оролцсон. Энэхүү хэргийн нэхэмжлэгч “Хил хязгааргүй алхам төв” ТББ нь нийтэд үйлчлэх төрийн бус байгууллага бөгөөд миний зүгээс нийгмийн сайн сайхны төлөө хуульчийн мэргэжлийн үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлж, стратегийн өмгөөлөл хийсэн болно. Үр дүн, түүний жишээ: Байгаль орчин, аялал жуулчлалын яамны цахим мэдээллийн санд байгаль орчны нөхөн сэргээлтийн төлбөрийг тусгай зөвшөөрөл бүхий компаниуд урьдчилж байршуулдаг болсон. Тодруулбал, БОНБУтХ-ийн 9.10 дахь заалт бодитоор хэрэгждэг болсон. Нотлох баримт: Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн захирамжийн хуулбар, Шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх тухай захирамж болон түүнтэй холбогдох бичиг баримтуудын хуулбар, өмгөөлөгчөөр оролцсоныг нотлох бичгийг хавсаргав. Үйл ажиллагааг удирдсан албан тушаалтан: Н.Баярсайхан Хамтран ажиллаж байсан хүн 1: Д.Эрдэнэчимэг Хамтран ажиллаж байсан хүн 2: Ч.Саранмандах Хамтран ажиллаж байсан хүн 3: Н.Баярсайхан
3.5	Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар 2010-одоог хүртэл Монголын Өмгөөлөгчийн холбооны гишүүн. 2006-одоог хүртэл Монголын Хуульчдын холбооны гишүүн.
3.6	Байгаа бол хэвлүүлсэн бүтээл болон олон нийтэд өгсөн мэдээлэл Өөрийн боловсруулсан, хянасан ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал 1. Мөрөөдлийн хүч, “Мөнхийн үсэг” ХХК, 2018 он (Солонгос хэлээс Монгол хэл рүү хөрвүүлсэн.) (БНСУ-ын нэр хүндтэй өмгөөлөгч Жон Сол Чон (АНУ-д хууль зүйн дээд боловсрол эзэмшиж, улмаар Америкийн алдартай хуулийн фирмийн партнер, Удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллаж байсан)-ны бичсэн “Мөрөөдлийн хүч” сургамжит бүтээлийг солонгос хэлнээс монгол хэлэнд хөрвүүлэн хуулийн сургуулийн оюутнууд болон хуульчдын хүртээл болгосон. Уг номны танилцуулга Монголын Хуульчдын холбооны веб сайтад тавигдсан). 2. Шүүхийн шийдвэрийн судалгаа цуврал 6, Нээлттэй нийгэм форум, 2022 он (Дуусгавар болсон актад холбогдуулан нэхэмжлэл гаргах эрх (Харьцуулсан эрх зүйн судалгаа) сэдвийн хүрээнд судалгаа хийсэн.) Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал 3. Монгол улс болон БНСУ-ын захиргааны хууль тогтоомж, “Мөнхийн үсэг” ХХК, 2020 он (2 улсын захиргааны хууль тогтоомжийн орчуулгыг хянасан.) 4. Хуулиа мэдье-Эрхээ хамгаалъя “Хайгуулын үе шат-иргэдийн эрхээ хамгаалахад зориулсан хууль тогтоомжийн тайлбар”, “Мөнхийн үсэг” ХХК, 2021 он (Уул уурхайн салбарын харилцааг зохицуулсан хууль

	тогтоомжуудыг иргэдэд ойлгомжтой байдлаар хялбаршуулан боловсруулсан.) 5. Хуулиа мэдье-Эрхээ хамгаалъя “Ашиглалтын үе шат-иргэдийн эрхээ хамгаалахад зориулсан хууль тогтоомжийн тайлбар” (Уул уурхайн салбарын харилцааг зохицуулсан хууль тогтоомжуудыг иргэдэд ойлгомжтой байдлаар хялбаршуулан боловсруулсан.) 6. Хуулиа мэдье-Эрхээ хамгаалъя “Хаалтын үе шат-иргэдийн эрхээ хамгаалахад зориулсан хууль тогтоомжийн тайлбар” (Уул уурхайн салбарын харилцааг зохицуулсан хууль тогтоомжуудыг иргэдэд ойлгомжтой байдлаар хялбаршуулан боловсруулсан.)
--	--

Хавсралт:

Нэр дэвших тухай хүсэлтэд журмын 5.1-д заасан дараах баримт бичгийг хавсаргана:

- төрийн албан хаагчийн анкет;
- иргэний үнэмлэхийн хуулбар;
- нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг;
- эрх зүйн бакалаврын, эсхүл түүнээс дээш боловсролын зэргийн дипломын хуулбар;
- хууль зүйн өндөр мэргэшилтэй гэдгийг нотлон харуулсан үйл ажиллагааны талаарх баримт;
- эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласныг нотлох баримт;
- хүсэлт гаргагчийн талаарх тодорхойлолт /гурваас доошгүй/;
- энэхүү загварт заасан баримт бичиг;
- холбогдох бусад баримт.

Хүсэлт гаргагч:

Эцэг/эхийн нэр: Гансүх

Өөрийн нэр: Буян

Гарын үсэг:

Он, сар, өдөр: 2025 оны 10 сарын 20-ны өдөр

--- оОо ---